



НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 05 03
Оны Сарын Есөр

026
Дугаар

Улаанбаатар хот

“Хос хийморь” ХХК-ийн гомдлын тухай

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг Б.Болормаа даргалж, гишүүд Д.Мэнхтуул, Х.Нямбаяр, Е.Наранбилэг, Б.Төгслхам, нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэй, “Хос хийморь” ХХК-аас Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2402201798 дугаар шийтгэлийн хуудсанд гаргасан гомдлыг, тус компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Ганхуяг, И.Ганчимэг, Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Туяа, Ш.Гэрэлзаяа нарыг оролцуулсан магадлагч-татварын улсын байцаагч Ж.Эрдэнэбүрэн магадлагагаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

1. “Хос хийморь” ХХК-ийн захирал Chang Tiezhi нь Татварын маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдолдоо: “Баянзүрх дүүргийн татварын хэлтэст харьялагддаг 5434017 регистрийн дугаартай “Хос хийморь” ХХК-ийн 2012-2016 оны албан татварын ногдуулалт, телелтийн байдалд Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Туяа, Ш.Гэрэлзаяа нар хяналт шалгалт хийж, 74,661,724.9 төгрөгийн нехен татвар, 84,048,139.0 төгрөгийн торгууль, 61,141,357.4 төгрөгийн алданги нийт 219,851,514.6 төгрөгийн төлбөр төлүүлэхээр 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 24/02201798 тоот шийтгэлийн хуудас бичсэн боловч манай компанийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул танай маргаан таслахад хандсан юм. Гэтэл 2017 оны 12 сарын 14-ний өдөр 712,345,675.0 төгрөгийн зөрчил ирүүлж, 240000274 тоот татварын улсын байцаагчийн дүгнэлт бичиж эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр хэрэг бүртгэх болон хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлсэн. БНХАУ-ын Xiamen C and Commodity trading компаниас манай компанийн “Голомт” банкны 1105075211 тоот дансанд махны үнэ 622,720.0 доллар буюу 1,247,607,065.6 төгрөг орж ирээд үүнээс махны үнэнд 266,996.0 доллар буюу 535,261,390.0 төгрөгийг гэрээний дагуу шилжүүлж харин үлдэгдэл 297,200.0 доллар буюу 712,345,675.0 төгрөгийг буцааж БНХАУ-ын Xiamen C and Commodity trading компани луу буцааж шилжүүлсэн. /баримтыг хавсаргав./

2016 оны бусдад олгосон хеделмерийн хэлс шилжүүлсэн орлогод татвар ногдуулах гэж 535,261,390.0 менгений орлого албан татвар суутган авч төсөөт төлөөгүй зөрчил нь 1. Аж ахуйн нэгийн орлогын албан татварын хуулийн 4.1.6-д заасан “суутгагч” нь дараах зүйлд «17.2.1. ногдол ашгийн орлогод 10 хувиар;

17.2.2. эрхийн шимтгэлийн орлогод 10 хувиар;

17.2.3.энэ хуулийн 16.6-д зааснаар тодорхойлсон төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод 40 хувиар;

17.2.4.эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, түүнчлэн эротик тогтолт явуулсан үйлчилгээний орлогод 40 хувиар;

17.2.5.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод 2 хувиар;

17.2.6.хүүгийн орлогод 10 хувиар;

17.2.7.эрх борлуулсны орлогод 30 хувиар;

17.2.8.гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газар вөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсан ашигийн 20 хувиар;

17.2.9.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон дараахь орлогод 20 хувиар:» татвар төлхөөр заасан нь манай компанийн энэ орлогод хамаarahгүй байгаа тул хүлээн зөвшөөрөхгүй байна.

Мөн Хувь хүний орлогын албан таварын тухай хуулийн 26.1 дэх заалтыг зөрчсөн гэжakt тогтоожээ. Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д «энэ хуулийн 11 дүгээр зүйл, 15.1-д заасан орлогын дунд 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дунд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дунд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дунд 23.2.3-т заасан хувиар, 12.2, 13.1.2, 13.1.3, 13.1.4-т заасан орлогын дунд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох тесэвт шилжүүлэх» гэж заасан байна. Эдгээр суутгал орлогыг жагсаавал: «11.1 Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хэлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараахь орлого хамаарна; 15 дугаар зүйл шууд бус орлого, 14.1.1 үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого; 8.1.6.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тогтолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого; 8.1.7.урлагийн тогтолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал; 8.1.8.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого; 12.2.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна. 13.1.2.эрхийн шимтээлийн орлого; 13.1.3.ногдол ашгийн орлого; 13.1.4.хүүгийн орлого»-оос «суутгагч»-ийн үүрэг хүлээхээр хуулийн заалтаас үзэхэд тус компанийд хамаarahгүй байна.

2. 2015, 2016 оны Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах 765,207,000.0 төгрөгийн зөрчилтэй гэж үзсэн нь: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д «Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараахь этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна» гэж зааснаар манай компани сэндвичээр барьсан тул өмчлөлийн гэрчилгээ олгогдолтуй тул үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөх үүрэг хүлээхгүй учраас энэ зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

3. 2013 онд нэмэгdsэн өргийн албан татварын тайланд тусгахдаа импортын бараа материал худалдан авсан 131,000,000.0 төгрөгийн зөрчилд ногдуулсан нөхөн татварыг төлхийг зөвшөөрч харин торгууль, алдангийн 10,480,000.0 төгрөгийг өршөөлийн хуульд хамруулж егөхийг хүсэж байна.

4. 2013, 2014, 2015, 2016 оны нэмэгdsэн өргийг хугацаандаа төлөөгүй 54,617,514.0 төгрөгийн торгууль, алдангийг "Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парlement байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуульд хамрагдах үндэслэлтэй гэж үзэж байгаа тул өршөөлийн хуульд хамруулж егнэ үү" гэж тэмдэглэсэн.

2. Татварын улсын байцаагч Б.Туяа, Ш.Гэрэлзаяа нар тайлбартай: "Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Б.Туяа, Ш.Гэрэлзаяа бид 2017 оны татварын эрсдэлд сууринсан төлөвлөгөөт хяналт шалгант, "татварын хяналт шалгыт хийх ерөнхий удирдамж", хяналт шалгалтын 24/17/0600338 тоот томилолтыг үндэслэн 5434017 тоот татвар төлөгчийн дугаартай "Хос хийморь" ХХК-ийн 2012 оны 1 дүгээр сарын 1-ээс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны албан татвар ногдуулалт, төлөлтийг шалгаад дараах зөрчилд Зөрчлийн тухай хууль болон Татварын ерөнхий хуулийг үндэслэн шийтгэлийн хуудас бичсэн. Үүнд:

"Хос хийморь" ХХК-ийн харилцах данс болох Голомт банкны 1105075221 тоот дансаар 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр иргэн Амарсайхан, Гончиг нарт адууны махны үнэ 535,261,390.0 төгрөгийн орлого шилжүүлсэн, олгосон орлогоос албан татвар сүүтган авч төсөвт төлөөгүй, сүүтгагчийн үргээ билэлүүлээгүй зөрчил нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.6."сүүтгагч" гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан сүүтгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг; ... мен Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх 26.3-д "Сүүтгагч нь албан албан татвар төлөгчийн орлогоос сүүтган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөв шилжүүлнэ." гэж заасан заалтыг зөрчсөн.

2014 оноос эхлэн компанийн бетон сүурьтай сэндвичийн үйлдвэрийн барилга болон оффисийн барилгаа баланс, данс бүртгэлдээ 765,207,000.0 төгрөгөөр бүртгэн тайлагнасан хирнээ үл хедлех эд хөрөнгийн албан татвар ногдуулж тайлагнаагүй зөрчил нь үл хедлех хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1-д "Газраас бусад үл хедлех эд хөрөнгийн албан татварыг уул хөрөнгийн үл хедлех эд хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн үнийн дүнгээр, бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлжно..."... мен хуулийн 8 дугаар зүйл 8.2-т "Үл хедлех эд хөрөнгө өмчлөгч хуулийн этгээд нь үл хедлех эд хөрөнгийн жилийн албан татварыг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр тооцож төлнэ."... гэж заасан заалтыг зөрчсөн.

2013 онд нэмэгдсэн өртгийн албан татварын тайландаа 131,000,000.0 төгрөгийн бараа материалыг импортоор оруулж ирсэн мэтээр хий бичилт бичиж нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт төлөлтийн тайлангийн "нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн импортын бараа, ажил үйлчилгээний дун" хэсэгт тусгаж худалдан авалтын хасалтанд тооцож төсөвт төлөх албан татварыг бууруулсан зөрчил нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д "Худалдан авагч нь бэлтгэн нийлүүлэгчид нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөн нь нэхэмжлэл, падаан болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг албан татварыг хасч тооцохгүй" гэж заасан заалтыг зөрчсөн.

Нэмэгдсэн өртгийн албан татварыг хуулийн хугацаанд төсөвт төлөөгүй 2014 онд 51,342,229.60 төгрөгийн, 2015 онд 65,290,023.00 төгрөгийн, 2016 онд 54,617,514.00 төгрөгийн зөрчил нь нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн 16 дугаар зүйл 16.1-д "Албан татвар сүүтган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор териийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албан тушаана" гэж заасан заалтыг тус зөрчсөнд шийтгэлийн хуудас бичсэн" гэж тэмдэглэсэн.

3. Магадлагч-татварын улсын байцаагч Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, тайлбар, татварын болон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, журналын бүртгэл зэрэг холбогдох материалд тулгуурлан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжид үндэслэн магадлагаа хийж, татварын улсын 2402201798 дугаар шийтгэлийн хуудсаар 2,367,925,157.1 төгрөгийн зерчил илрүүлж 74,661,724.0 төгрөгийн нэхөн татвар, 84,048,433.2 төгрөгийн торгууль, 61,141,357.4 төгрөгийн алданги бүгд 219,851,514.6 төгрөгийн төлбөр ногдуулснаас 53,526,139.0 төгрөгийн нэхөн татвар, 16,057,841.7 төгрөгийн торгууль, 20,717,870.1 төгрөгийн алданги нийт 90,301,850.8 төгрөгийн төлбөрийг хүчингүй болгон, 60,558,710.1 төгрөгийн торгууль, 36,026,811.8 төгрөгийн алданги бүгд 96,585,521.9 төгрөгийг өршөөлд хамруулж, 4,943,484.6 төгрөгийн зерчилд 21,135,585.0 төгрөгийн нэхөн татвар, 7,431,881.4 төгрөгийн торгууль, 4,396,675.8 төгрөгийн алданги нийт 32,964,142.2 төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийтгэлийн хуудсыг өөрчлөх гасэн саналыг оруулсан.

ҮНДЭСЛЭХ НЬ:

"Хос хиймарь" ХХК-ийн 2012-2016 оны албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Туяа, Ш.Гэрэлзаяа нар шалгалт хийж, татварын улсын байцаагчийн 2402201798 дугаар шийтгэлийн хуудсаар 4 төрлийн 2,367,925,157.1 төгрөгийн зерчил илрүүлж 74,661,724.0 төгрөгийн нэхөн татвар, 84,048,433.2 төгрөгийн торгууль, 61,141,357.4 төгрөгийн алданги бүгд 219,851,514.6 төгрөгийн төлбөр ногдуулсныг эс зөвшеөрч гомдол гаргасан. Үүнд:

1. 2402201798 дугаар шийтгэлийн хуудасны зерчлийн жагсаалтын 1-д: 2016 онд 535,261,390.0 төгрөгийн орлого олгоод олгосон орлогоос албан татвар суутган авч төсөвт төлөөгүй зерчил нь Ах ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дах заалтыг зерчсөн гэж тэмдэглээд Татварын еренхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 дах заалтыг үндэслэн захиргааны харицлага хүлээлгэсэнд энэ орлогоос суутгачийн үүрэг хүлээхгүй, хуулинд заагаалгүй гэж маргажээ.

"Хос хиймарь" ХХК нь Голомт банкны 1105075221 тоот төгрөгийн данснаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Голомт банкны 1501164451 тоот Ц.Амарсанаагийн /Р377101413/ дансанд 15000 долларыг адууны махны үнэ гасэн гүйлгээний утгатай, 2016 оны 1 дүгээр сарын 18-нд Голомт банкны 1405104007 тоот Г.Хадхуүгийн /Х381042612/ дансанд 257,343,750.0 төгрөгийг адууны махны үнэ гүйлгээний утгатай, мөн өдөр Хаан банкны 6030072588 тоот Ц.Амарсанаагийн дансанд 247,656,340.0 төгрөгийн адууны махны үнэ гасэн гүйлгээний утгатайгаар тус тус шилжүүлжээ.

Тус компани нь дээрх иргэдээс суутгачийн үүрэг хүлээхээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд хуульчлаагүй байна. Учир Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д «суутгач» гэж албан татвар төлөгчийн орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг», мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д «Суутгач нь энэ хуулийн 8.1.7, 8.1.8, 11 дүгээр зүйл, 13.1.2-13.1.4, 14.1.1, 15 дугаар зүйлд заасны дагуу суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албандаа ирүүлнэ» гэж заасан буюу 8.1.7.урлагийн тогтолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал; 8.1.8.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого; 11

дүгээр зүйл "албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хэлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилттах хөдөлмөр эрхлэлтийн орлого"; 13.1.2.эрхийн шимтгэлийн орлого; 13.1.3.ногдол ашгийн орлого; 13.1.4.хүүгийн орлого; 14.1.1.ул хедлөх эд хөрөнгө борлуулсны орлого; 15 дугаар зүйл "шууд бус орлого"; гэсэн орлогуудаас сүүтгачийн үүрэг хүлээхээр хуульчилсан бөгөөд үйл ажиллагааны орлогоос сүүтгачийн үүрэг хүлээхгүй байна.

Иймд шийтгэлийн хуудсаар ногдуулсан 53,526,139.0 төгрөгийн нөхөн татвар, 16,057,841.7 төгрөгийн тorgтуль, 19,076,716.0 төгрөгийн алданги нийт 88,660,696.7 төгрөгийн төлбөрийг хүчингүй болгох нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

2. 2402201798 дугаар шийтгэлийн хуудасны зөрчлийн жагсаалтын 2-д: 2015 онд 765,207,000.0 төгрөгийн, 2016 онд 765,207,000.0 төгрөгийн үл хедлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж төсөөт төлөөгүй зөрчил нь Үл хедлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйлийн 8.2 дах заалтыг зөрчсөн гэж тэмдэглээд Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 дах заалтыг үндэслэн захиргааны хариуцлага хүлээлгэсэнд манайх үл хедлөх хөрөнгийн өмчлөх гарчилгээ гарваагүй тул татвар төлөхгүй гэж маргасан.

Тус компани нь Баянгол дүүргийн 20 дугаар хороо Үйлдвэрийн баруун бүс Эрчим хүчний гудамж 18/2 тоот хаягт байрлалтай 378 м² талбайтай үйлдвэрлэлийн зориулалттай Y-2205057686 бүртгэлийн дугаартай үл хедлөх хөрөнгө, Баянгол дүүргийн 20 дугаар хороо Үйлдвэрийн баруун бүс Эрчим хүчний гудамж 18/1 тоот хаягт байрлалтай 588 м² талбайтай үйлдвэрлэлийн зориулалттай Y-2205044826 бүртгэлийн дугаартай үл хедлөх эд хөрөнгө өмчилдөг болохыг Нийслэлийн улсын бүртгэлийн газраас 2014 оны 7 дугаар сарын 8, 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр олгосон Үл хедлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гарчилгээгээр тус тус нотлогдож байна.

"Хос хийморь" ХХК нь үл хедлөх эд хөрөнгө өмчлөгчийн гарчилгээ авсан хэдий ч Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулиар үл эд хедлөх хөрөнгийг ил болгож тайлгнасан.

Иймд Үл хедлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д «Газраас бусад үл хедлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хедлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хедлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно», 8 дугаар зүйлийн 8.2-д «Үл хедлөх эд хөрөнгө өмчлөгч хуулийн этгээд нь үл хедлөх эд хөрөнгийн жилийн албан татварыг улирал бурийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр тооцож төлнө» гэсэн заалтыг зөрчсөн байх тул Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3. Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19 дах заалтыг үндэслэн 8,035,585.0 төгрөгийн нөхөн татвар, 2,410,675.6 төгрөгийн тorgтуль, 3,248,271.1 төгрөгийн алданги ногдуулсан нь зөв хэдий ч Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.5-д "Шинээр зөрчилд тооцсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хүндруулсан, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрзглэхгүй", мөн Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1-д «Хуульд заасны дагуу нөхөн төлүүлэх болон хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд уг алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхээргүй байна. /Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/» гэж заасныг үндэслэн 1,607,117.0 төгрөгийн алдангийг ногдуулж, илүү ногдуулсан 1,641,154.1 төгрөгийн алдангийг хүчингүй болгох нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.

3. 2402201798 дугаар шийтгэлийн хуудасны зерчлийн жагсаалтын 3-д: 2013 онд 131,000,000.0 төгрөгийн бараа материалыг импортоор оруулж ирсэн мэтээр хий бичилт бичиж нэмэгдсэн өргтийн албан татварын тайландаа тусгасан зерчил нь Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг зерчсөн гэж тэмдэглээд Татварын еренхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 заалтын дагуу хариуцлага хүлээлгэсэнд өршөөлийн хуульд хамруулах хүсэлт гаргасан.

Тус компани 2013 онд 131,000,000.0 төгрөгийн бараа материалыг импортоор оруулж ирэхдээ давхар бүртгэсэн нь нэмэгдсэн өргтийн албан татварын тайлангаар нотлогдож байх тул Татварын еренхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 дахь заалтыг үндэслэн 13,100,000.0 төгрөгийн нөхөн татвар, 3,930,000.0 төгрөгийн торгууль, 6,550,000.0 төгрөгийн алданги ногдуулсан ч "Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д «Хууль тогтоомж зерчиж захиргааны зерчил гаргасан болон шийтгэл хүлээсэн этгээдийг өршөөн хэлтрүүлнэ.», 10 дугаар зүйлийн 10.1-д «Энэ хуулийн 3.1-д заасан "гэмт хэрэг үйлдсэн хүн" гэдэгт 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө гэмт хэрэг үйлдсэн болон ял шийтгүүлсэн, захиргааны зерчил гаргасан болон шийтгэл хүлээсэн хүн хамаарна» гэж заасныг үндэслэн 3,930,000.0 төгрөгийн торгууль, 6,550,000.0 төгрөгийн алданги бүгд 10,480,000.0 төгрөгийн хариуцлагыг өршөөх нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

4. 2402201798 дугаар шийтгэлийн хуудасны зерчлийн жагсаалтын 4-д: 2014 онд 51,342,229.6 төгрөгийн, 2015 онд 65,290,023.0 төгрөгийн, 2016 онд 54,617,514.0 төгрөгийн нэмэгдсэн өргтийн албан татварыг хуулийн хугацаанд төлөөгүй зерчил нь Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь заалтыг зерчсөн гэж тэмдэглээд Татварын еренхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.3 заалтын дагуу хариуцлага хүлээлгэсэнд өршөөлийн хуульд хамруулах хүсэлт гаргасан.

Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д «Албан татвар суутган телегч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор терийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана:» гэсэн заалтыг зерчиж, Татварын еренхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т «Татварыг хугацаанд нь төлөөгүй бол телегдээгүй татварын дунд хугацаа хэтэрсан хоног тутамд 0.1 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.», 74.3-т «Энэ хуулийн 74.1, 74.2-т заасны дагуу нөхөн төлүүлэх болон хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд уг алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын үнийн дунгийн 60 хувиас хэтрэхээргүй байна.» гэж заасныг үндэслэн 61,649,915.9 төгрөгийн торгууль, 32,266,370.3 төгрөгийн алданги ногдуулсан нь үндэслэлтэй боловч "Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.1 дахь заалтыг үндэслэн 56,628,710.1 төгрөгийн торгууль, 29,476,811.8 төгрөгийн алданги бүгд 86,105,521.9 төгрөгийн хариуцлагыг өршөөх, өршөөгдөх хугацаанаас хойш ногдуулсан 5,021,205.8 төгрөгийн торгууль, 2,789,558.8 төгрөгийн алданги нийт 7,810,764.8 төгрөгийн төлбөрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.

Татварын еренхий хуулийн 42 дугаар зүйлийн 7 дахь заалтыг удирдлага болгон
ТОГТООХ НЬ:

1. Татварын еренхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.2, 74.3, Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай /2006 оны/ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 16 дугаар зүйлийн 16.1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1,

28 дугаар зүйлийн 28.1, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйлийн 8.2, Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.5, 11 дүгээр зүйлийн 11.19, "Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг баримтлан татварын улсын байцаагчийн 2402201798 дугаар шийтгэлийн хуудсаар 2,367,925,157.1 төгрөгийн зөрчил илрүүлж 74,661,724.0 төгрөгийн нөхөн татвар, 84,048,433.2 төгрөгийн торгууль, 61,141,357.4 төгрөгийн алданги бүгд 219,851,514.6 төгрөгийн төлбөр ногдуулснаас 53,526,139.0 төгрөгийн нөхөн татвар, 16,057,841.7 төгрөгийн торгууль, 20,717,870.1 төгрөгийн алданги нийт 90,301,850.8 төгрөгийн төлбөрийг хүчингүй болгон, 60,558,710.1 төгрөгийн торгууль, 36,026,811.8 төгрөгийн алданги бүгд 96,585,521.9 төгрөгийг өршөөлд хамруулж, 1,832,663,767.1 төгрөгийн зөрчилд 21,135,585.0 төгрөгийн нөхөн татвар, 7,431,881.4 төгрөгийн торгууль, 4,396,675.8 төгрөгийн алданги нийт 32,964,142.2 төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийтгэлийн хуудсыг өөрчилсүгэй.

2. Шийдвэрийг эс зөвшөөрөвэл шийтгэлийн хуудсанд гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ХУРАЛ ДАРГАЛСАН: *Б.Болормаа* Б.БОЛОРМАА
ГИШҮҮД: *Д.Мөнхтуул* Д.МӨНХТУУЛ
Х.Нямбаяр Х.НЯМБАЯР
Е.Наранбилэг Е.НАРАНБИЛЭГ
Б.Төгслхам Б. ТӨГСЛХАМ
Ж.Эрдэнэбурэн Ж. ЭРДЭНЭБҮРЭН